| Техникийн болон ажлын талбайн өгөгдөл .....       | 3  |
| Ажлын талбайн харуул хамгаалалт .....             | 3  |
| Хог, хаягдал ба нөхөн сэргээлт .....              | 4  |
| Археологийн болон бусад олдвор .....              | 4  |
| Аюулгүй байдал .....                              | 4  |
| ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН ..... | 4  |
| Ажил эхлэх .....                                  | 4  |
| Хугацаа сунгах .....                              | 5  |
| Ажлын явцын тайлан .....                          | 5  |
| ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ .....       | 5  |
| Гэрээний үнэ .....                                | 5  |
| Урьдчилгаа төлбөр .....                           | 6  |
| Төлбөрийн нөхцөл .....                            | 6  |
| ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА .....       | 6  |
| Урьдчилгаа төлбөрийн баталгаа .....               | 6  |
| Гүйцэтгэлийн баталгаа .....                       | 6  |
| Чанарын баталгаа .....                            | 7  |
| Баталгаат хугацаа .....                           | 7  |
| ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ .....                    | 7  |
| Бусдад учруулсан хохирлыг арилгах .....           | 7  |
| Захиалагчийн хүлээх эрсдэл .....                  | 7  |
| Даатгал .....                                     | 8  |
| НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ .....               | 8  |
| Доголдлыг илрүүлэх, арилгах .....                 | 8  |
| Далд доголдол .....                               | 9  |
| Зураг төслийн доголдол .....                      | 9  |
| ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ .....                           | 9  |
| Захиалагч гэрээг цуцлах .....                     | 9  |
| Гүйцэтгэгч гэрээг цуцлах .....                    | 9  |
| Гэрээг цуцлах журам .....                         | 10 |
| Гэрээг цуцалсны дараах төлбөр .....               | 10 |
| АРАВ. БУСАД ЗААЛТ .....                           | 11 |
| Мэдэгдэл .....                                    | 11 |

|   |    |
|---|----|
| Төлөөлөгч өөрчлөгдөх.....   | 11 |
| Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл.....                          | 11 |
| Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал ..... | 12 |
| Оюуны өмчийн эрх зөрчих .....                                       | 12 |
| Алданги .....   | 12 |
| Маргаан шийдвэрлэх.....   | 13 |
| ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ .....  | 14 |
| ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ .....                                    | 15 |

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

### Тодорхойлолт

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл ндор дурдсан утгыг агуулна:

- 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
- 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
- 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
- 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
- 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
- 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
- 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
- 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
- 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

|                                   |  |
|-----------------------------------|--|
| <b>Тайлбар</b>                    | <p>1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <ul style="list-style-type: none"> <li>1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.</li> <li>1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</li> <li>1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</li> <li>1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</li> <li>1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</li> </ul> |
|                                   | <b>ХОЁР. ЗАХИАЛАГЧ</b>   |
| <b>Захиалагчийн нийтлэг үүрэг</b> | <p>2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.</p> <p>2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.</p> <p>2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.</p>  |
| <b>Захиалагчийн төлөөлөгч</b>     | <p>2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.</p> <p>2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p>   |
| <b>Талбайд нэвтрэх зөвшөөрөл</b>  | <p>2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.</p> <p>2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.</p>  |

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- |  |   |
|--|---|
| <b>Гүйцэтгэгчийн нийтлэг<br/>үүрэг</b>               | 3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.   |
| <b>Гүйцэтгэгчийн<br/>төлөөлөгч</b>                   | 3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.   |
| <b>Техникийн болон<br/>ажлын талбайн<br/>өгөгдөл</b> | 3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.   |
| <b>Ажлын талбайн<br/>харуул хамгаалалт</b>           | 3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгчхариуцна.  |
|  | 3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 10 (арав) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.   |
|  | 3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.   |
|  | 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.  |
|  | 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.  |
|  | 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.   |
|  | 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.   |
|  | 3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.   |
|  | 3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.   |
|  | 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна. |

- |                                       |  |
|---------------------------------------|--|
| <b>Хог, хаягдал ба нөхөн сэргээлт</b> | 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.<br>3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалыудыг зохих ёсоор хадгалж, устгана.<br>3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.<br>3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө. |
| <b>Археологийн болон бусад олдвор</b> | 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.<br>3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.  |
| <b>Аюулгүй байдал</b>                 | 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.<br>3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.<br>3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.<br>3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.<br>3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.<br>3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.  |

## ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

- |                   |  |
|-------------------|--|
| <b>Ажил эхлэх</b> | 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.<br>4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.<br>4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын |
|-------------------|--|

|                           |   |
|---------------------------|---|
|                           | үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.   |
| <b>Хугацаа сунгах</b>     | <p>4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.</p> <p>4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <ul style="list-style-type: none"> <li>4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;</li> <li>4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;</li> <li>4.5.3. Захиалагч хугацаандaa төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;</li> <li>4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.</li> </ul>   |
| <b>Ажлын явцын тайлан</b> | <p>4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.</p> <p>4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.</p> <p>4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.</p> <p>4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.</p> |

#### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

|                     |  |
|---------------------|--|
| <b>Гэрээний үнэ</b> | <p>5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>5.2. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.</p> <p>5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> |
|---------------------|--|

- |                          |   |
|--------------------------|---|
| <b>Урьдчилгаа төлбөр</b> | <p>5.4. Тендерийн баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p>   |
| <b>Төлбөрийн нөхцөл</b>  | <p>5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.</p> <p>5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.</p> <p>5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p> |

## **ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА**

- |                                      |   |
|--------------------------------------|---|
| <b>Урьдчилгаа төлбөрийн баталгаа</b> | <p>6.1. ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.</p>  |
| <b>Гүйцэтгэлийн баталгаа</b>         | <p>6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар ТӨХ-д заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.</p> <p>6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;</li> <li>6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</li> <li>6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.</li> </ul> |

- |  |  |
|--|--|
| <b>Чанарын баталгаа</b>                  | <p>6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.</p> <p>6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.</p> <p>6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.</p>  |
| <b>Баталгаат хугацаа</b>                 | <p>6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.</p> <p>6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>6.9. ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг сутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.</p> <p>6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> <p>6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.</p> |
| <b>ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ</b>          |  |
| <b>Бусдад учруулсан хохирлыг арилгах</b> | <p>7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.</p>   |
| <b>Захиалагчийн хүлээх эрсдэл</b>        | <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;</p> <p>7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах</p>   |

- үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөрөмж гэмтсэн, устсан;
  - 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- Даатгал**
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
  - 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
  - 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
  - 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
  - 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
  - 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

## НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

- Доголдлыг илрүүлэх, арилгах**
- 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
  - 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
  - 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
  - 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
  - 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
  - 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
  - 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.

|                                 |  |
|---------------------------------|--|
| <b>Далд доголдол</b>            | 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.<br>8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.   |
| <b>Зураг төслийн доголдол</b>   | 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.<br>8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.   |
| <b>Захиалагч гэрээг цуцлах</b>  | <p style="text-align: center;"><b>ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ</b></p> 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: <ul style="list-style-type: none"> <li>9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;</li> <li>9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гаралгүй;</li> <li>9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;</li> <li>9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгальн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;</li> <li>9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</li> <li>9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 10 (арав)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;</li> <li>9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.</li> <li>9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.</li> </ul> 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно. |
| <b>Гүйцэтгэгч гэрээг цуцлах</b> | 9.3. Гүйцэтгэг дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: <ul style="list-style-type: none"> <li>9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;</li> </ul>   |

- |                                      |  |
|--------------------------------------|--|
| <b>Гэрээг цуцлах журам</b>           | <p>9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> <p>9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.</p>   |
| <b>Гэрээг цуцалсны дараах төлбөр</b> | <p>9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p> <p>9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.</p> <p>9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.</p> <p>9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:</p> <ul style="list-style-type: none"> <li>9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;</li> <li>9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;</li> <li>9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;</li> <li>9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;</li> <li>9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.</li> </ul> |

## АРАВ. БУСАД ЗААЛТ

### **Мэдэгдэл**

- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
  - 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
  - 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

### **Төлөөлөгч өөрчлөгдөх**

- 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.

### **Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл**

- 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын өрөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.

**Гэнэтийн буюу  
давагдашгүй хүчний  
шинжтэй онцгой  
нөхцөл байдал**

**Оюуны өмчийн эрх  
зэрчих**

**Алданги**

- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-д заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- 10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.
- 10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дунгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дунгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.

**Маргаан шийдвэрлэх**

- 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

|            |  |
|------------|--|
| ГЕН 4.1.   | Ажил эхлэх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b>   |
| ГЕН 4.2.   | Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b>   |
| ГЕН 4.9.   | Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b>  |
| ГЕН 5.2.   | Үнийн тохируулга: <b>“Хийхгүй”</b>   |
| ГЕН 5.4.   | Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <b>“Үгүй”</b>  |
| ГЕН 5.5.   | Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: <b>“Үгүй”</b>   |
| ГЕН 5.6.   | Төлбөр төлөх хугацаа: <b>[он, сар, өдөр]</b><br>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: <b>[он, сар, өдөр]</b>                                    |
| ГЕН 6.1.   | Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: <b>“Үгүй”</b>   |
| ГЕН 6.8.   | <b>Чанарын баталгаа:</b><br>Чанарын баталгаа шаардах эсэх: <b>“Шаардана.”</b><br>Чанарын баталгаа шаардах бол,<br>Чанарын баталгааны хэмжээ: Гэрээний үнийн дунгийн 5%   |
| ГЕН 6.14.  | Баталгаат хугацаа: Тухайн орон нутгийн холбогдох төрийн байгууллагад ажлын гүйцэтгэлийг хүлээлгэн өгч актаар баталгаажуулах хүртэлх хугацаанд баталгаат хугацааг тооцно. |
| ГЕН 7.5.   | Даатгал: Машин механизуудыг даатгуулсан байна.   |
| ГЕН 10.21. | <b>Захиалагчийн төлөх алдангийн хувь:</b><br>Алдангийн хувь: <b>“Үгүй”</b>   |
| ГЕН 10.22. | <b>Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:</b><br>Алдангийн хувь: <b>“Үгүй”</b>  |

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

.....хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
  - 3.7. Техникийн тодорхойлолт;
  - 3.8. Ажил гүйцэтгэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнэ. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

## **Гүйцэтгэлийн баталгааны маягт (Банкны)**

Баталгаа хүлээн авагч: **[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

1. **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь **[ажлын төвч тодорхойлолт]-ыг гүйцэтгэх зорилгоор **[Гэрээний нэр ба дугаарыг бичих]** (цаашид “гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.**
2. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]-ийн төлбөрийн үүрэг хүлээж **[баталгааны дүн тоогоор]** **[дүн үсгээр]** баталгаа гаргаж байна.**
3. Гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнд ямар нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь захиалагчийн дараах мэдэгдлийг ирүүлэх хүртэл хугацаанд хүчинтэй байна:
  - 5.1. төсвийн жил дамжин гүйцэтгэх гэрээний шинэчилсэн гүйцэтгэлийн баталгааг захиалагч хүлээн авсан; эсхүл
  - 5.2. гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дууссаныг захиалагч хүлээн зөвшөөрсөн.
6. Энэхүү баталгааг хүчингүй болгоход зөвхөн захиалагчийн зөвшөөрлийг үндэслэх ба бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

**Баталгаа гаргасан,**

Банкны эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалтын нэр:

Албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга, тэмдэг

Огноо:

Хаяг:

## Гүйцэтгэлийн баталгааны маят

(Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны)

Баталгаа хүлээн авагч: **[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

1. **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]** нь (цаашид “Нийлүүлэгч” гэх) **[ажлын товч тодорхойлолт]**-ыг гүйцэтгэх зорилгоор **[Гэрээний нэр ба дугаарыг бичих]** (цаашид “гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн төлбөрийн үүрэг хүлээж **[баталгааны дүн тоогоор]** **[дүн үсгээр]** нэрлэсэн үнэ бүхий **[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр]** (цаашид “Үнэт цаас” гэх)<sup>6</sup> үндэслэн баталгаа гаргаж байна.
3. Гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлөх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Үнэт цаасыг Захиалагчийн нэр дээр шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямар нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь захиалагчийн дараах мэдэгдлийг ирүүлэх хүртэл хугацаанд хүчинтэй байна:
  - 5.1. төсвийн жил дамжин гүйцэтгэх гэрээний шинэчилсэн гүйцэтгэлийн баталгааг захиалагч хүлээн авсан; эсхүл
  - 5.2. гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дууссаныг захиалагч хүлээн зөвшөөрсөн.
6. Энэхүү баталгааг хүчингүй болгоход зөвхөн захиалагчийн зөвшөөрлийг үндэслэх ба бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

**Баталгаа гаргасан,**

Эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалтын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга:

Огноо:

Хаяг:

<sup>6</sup> Засгийн газрын бондын болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь гэрээний хэрэгжиж дуусах хугацаанаас 3-аас доoshгүй сарын дараа байна.

## **Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт (Банкны)**

Баталгаа хүлээн авагч: **[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[Урьдчилгаа төлбөрийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

1. **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь **[ажлын төвч тодорхойлолт]-ыг** гүйцэтгэх зорилгоор **[Гэрээний нэр ба дугаарыг бичих]** (цаашид “гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө урьдчилгаа төлбөрийн дүнгээр буюу нийт **[мөнгөн дүн]-ийн** төлбөрийн үүрэг хүлээж **[баталгааны дүн тоогоор]** **[дүн үсгээр]** баталгаа гаргаж байна.
3. Гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь **[огноо бичих]** хүртэл хугацаанд хүчинтэй байх ба Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

**Баталгаа гаргасан,**

Банкны эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалтын нэр:

Албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга, тэмдэг

Огноо:

Хаяг:

## Үрьдчилгаа төлбөрийн баталгааны маягт

(Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны)

Баталгаа хүлээн авагч: **[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[Үрьдчилгаа төлбөрийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

1. **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]** нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) **[ажлын товч тодорхойлолт]**-ыг гүйцэтгэх зорилгоор **[Гэрээний нэр ба дугаарыг бичнэ]** (цаашид “гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө үрьдчилгаа төлбөрийн дүнгээр буюу нийт **[мөнгөн дүн]**-ийн төлбөрийн үүрэг хүлээж **[баталгааны дүн тоогоор]** **[дүн үсгээр]** нэрлэсэн үнэ бүхий **[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр]** (цаашид “Үнэт цаас” гэх)-г<sup>7</sup> үндэслэн баталгаа гаргаж байна.
3. Гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлөх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Үнэт цаасыг Захиалагчийн нэр дээр шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямар нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь **[огноо бичих]** хүртэл хугацаанд хүчинтэй байх ба Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстай.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

**Баталгаа гаргасан,**

Эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга:

Огноо:

Хаяг:

<sup>7</sup> Засгийн газрын бондын болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь гэрээний хэрэгжиж дуусах хугацаанаас 3-аас доoshгүй сарын дараа байна.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо<sup>8</sup> : 2023.12.28

Тендер шалгаруулалтын нэр: “Насос станцын барилгын дээврийн засвар үйлчилгээг иж бүрэн шинээр хийлгэх”

Тендер шалгаруулалтын дугаар: ДААТҮТӨХК/2023102411

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг “Насос станцын барилгын дээврийн засвар үйлчилгээг иж бүрэн шинээр хийлгэх” - ын ажлыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: “Үгүй”

Багц 1:

Багц 2:

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш [30] ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заах ба : 596,504 /таван зуун ерөн зургаан мянга таван зуун дөрөв төгрөг<sup>9</sup> төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.<sup>10</sup>

Тендерийг 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн, 10 цаг 10 минутад<sup>11</sup> зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх:<sup>12</sup> “Эрхгүй”

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: “Үгүй”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,  
Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК,  
[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

<sup>8</sup> Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.

<sup>9</sup> Төсөвт өртгийн 1-2 хувьтай тэнцүү байна.

<sup>10</sup> 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил, 70 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, зөвлөхөөс бусад үйлчилгээ худалдан авахад тендерийн баталгаа шаардана.

<sup>11</sup> Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

<sup>12</sup> Хуулийн 9.3-т зааснаас бусад тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулж үл болно.